



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД
СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО
ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАНГААС**

**ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН
ДҮНГЭЭС**



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮР ДҮНД СУУРИЛСАН
САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООНД ШИЛЖСЭНЭЭР ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ САЙЖИРЧ БАЙГАА ХЭДИЙ Ч ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ОРХИГДОЖ БОЛЗОШГҮЙ БАЙНА.**

АГУУЛГА

1

А. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

А1. Хөгжлийн бодлогын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт эрүүл мэндийн чиглэлээр тусгасан арга хэмжээний талаар


2

Б. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ДААТГУУЛАГЧДАД ҮЗҮҮЛЖ БАЙГАА ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

Б.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын талаар

Б.2. Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтын тогтолцооны талаар

Б.3. Эрүүл мэндийн даатгалын салбарын хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааны талаар





ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС



**Төрөөс баримтлах
бодлогын баримт
бичгүүдэд эрүүл мэндийн
чиглэлээр тусгасан зорилт,
арга хэмжээний уялдаа холбоо,
хэрэгжилтийг орон нутгийн түвшинд
ханган ажиллаж байна**



**Аймгийн засаг даргын 2020-2024
оны үйл ажиллагааны хөтөлбөр,
аймгийн хөгжлийн 2021, 2022
оны төлөвлөгөөнд эрүүл мэндийн
чиглэлээр дараах арга хэмжээг
хэрэгжүүлэн ажилласан байна**

Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн
сан бүрдүүлэх

01

Орон нутагт хийгдэх оношилгоо
эмчилгээнд алсын зайн технологи
ашиглах

02

Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн
оновчтой арга хэлбэрийг нэвтрүүлэх үйл
ажиллагааг дэмжих

03

Эм эмнэлгийн хэрэгслийн чанар
аюулгүй байдлыг хангах

04

Хяналтын цахим
тогтолцоонд шилжих

05

AUDIT

АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ



Бодлогын хүрээнд Аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн 2021, 2022 оны төлөвлөгөөнд эрүүл мэндийн чиглэлээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс 75.5 хувьтай үнэлжээ.




Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгал,
үр дүнд суурилсан санхүүжилтийн
тогтолцоо үр нөлөөнд хийсэн аудитын
тайлан

01



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.




2022 онд ажил олгогч даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 2.6 дахин өндөр төлөвлөсөнтэй холбоотой орлого бүрэн төвлөрөөгүй байна.

Эрүүл мэндийн даатгалд малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутан суралцагчийн хамрагдалт хангалтгүй буюу 2022 онд 2-22 хувьтай байна


2021 онд

3,837.5 сая төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэл 98% буюу 3,789.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ.



2022 онд

9,401.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 4,529.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ



Эх сурвалж: 2022 онд хийсэн Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо үр нөлөөнд хийсэн аудит



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС

- 2021 онд аймгийн **ЭМДХ** нь **ЭМБ**-уудаас ирүүлсэн 367,653 хүний 24,592.1 сая төгрөгийн нэхэмжлэлд эмч байцаагчийн хяналтыг хийж 4851 хүний 2,916.9 сая төгрөгийн нэхэмжлэлд хасалт хийсэн бөгөөд ковид-19 цар тахалтай холбоотой нөхцөл байдлын улмаас ЭМДС-аас 4,146.5 сая төгрөгийн дутуу буюу 17,528.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- 2022 онд 431,109 хүний 30,588.1 сая төгрөгийн нэхэмжлэлийг хянаж 6055 хүний 1,925.9 сая төгрөгийн нэхэмжлэлд хасалт хийж гүйцэтгэлээр 28,662.2 сая төгрөгийг олгохоор тооцсон боловч урьд оны өрийг бүрэн барагдуулж, 39.7 сая төгрөгийн авлага үүсгэж 32,848.4 сая төгрөгийн санхүүжилтыг тус тус олгосон байна.





ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС



Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ын дагуу аймгийн хэмжээнд 2021 онд 48 эмийн сан, 29 эрүүл мэндийн байгууллага давхардсан тоогоор 21 тусламж үйлчилгээг худалдан авахаар, 2022 онд 41 эмийн сан, 30 эрүүл мэндийн байгууллага давхардсан тоогоор 24 тусламж үйлчилгээг худалдан авахаар сонгон шалгаруулалтад оролцож, гэрээг байгуулсан байна.



Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын эмийн үлдэгдэлд ковид-19 цар тахлын үед ЭМЯ-наас хандиваар ирсэн 2023 онд хугацаа дуусах нийт 570.4 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл байгаагаас 58.3 хувь буюу 332.3 сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл нь хугацаа нь дуусаж ашиглагдахааргүй байна.



Шинэ тогтолцоонд шилжсэнээр ЭМБ-уудын үзүүлэх тусламж үйлчилгээний төрөл, хүртээмж нэмэгдэх, тусламж үйлчилгээний төвлөрөл саарах, даатгуулагчийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах, эмнэлгүүдийн хооронд шударга өрсөлдөөнийг бий болгож, эмнэлгийн гүйцэтгэлийг сайжруулах сайн талтай ч хэт гүйцэтгэлийн тоонд анхаарснаар тусламж үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж, шаардлагагүй тусламж үйлчилгээний тоо нэмэгдэж болзошгүй байна.

2021-2022 онуудад ЭМД-ын сангаас олгосон санхүүжилт



2021-2022 онуудад иргэдэд үзүүлсэн тусламж үйлчилгээний тоо



Эх сурвалж: 2022 онд хийсэн Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо үр нөлөөнд хийсэн аудит



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн хяналтын зарим чиг үүрэг бүрэн хэрэгжихгүй байна


2022 онд нийт 71 байгууллагын 431,109 хүний нэхэмжлэлд системийн болон эмч байцаагчийн хяналтыг, 32 эрүүл мэндийн байгууллага буюу 45 хувьд нь газар дээрх хяналт шалгалтыг хийсэн байна.



Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэст жилд дунджаар 399,381 хүний нэхэмжлэл ирдэг бөгөөд нэг байцаагч жилд дунджаар 133,127 хүний, сард 11,093 хүний нэхэмжлэлд цахим болон эмч байцаагчийн хяналтыг хэрэгжүүлдэг байна.



Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь бодит буюу нөхцөл байдал дээрх хяналтыг 2022 онд аймгийн төвийн 19-н эрүүл мэндийн байгууллага, 2 сумын 6-н эрүүл мэндийн байгууллага нийт 25-н эрүүл мэндийн байгууллагад хийжээ



Тус хэлтэс нь 2021-2022 онд хяналт шалгалт чанарын үнэлгээ хийх чиг үүргийн дагуу аймгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа 75 байгууллагын 9.3-33.3 хувийг хамруулан шалгасан боловч чанар, төлбөрийн хяналтад дүн шинжилгээ хийж тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС

Орон нутагт зайлшгүй шаардлага үүссэн нөхцөлд гэрээнд тусгаагүй тусламж үйлчилгээг үзүүлснээр эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авч чадахгүй тохиолдол гарч байна.

Аймгийн хэмжээнд 2021, 2022 онуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авахаар 95-98 байгууллага сонгон шалгаруулалтад оролцож гэрээ байгуулсан байна.



Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулдаггүй, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын сонгон шалгаруулалт гэрээлэлтийн асуудал хариуцсан нэгж нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ын 3.1-т заасны дагуу зохион байгуулж байна



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС

2021-2022 онд орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь эрүүл мэндийн байгууллагуудын гэрээний хэрэгжилтийг 85-95 оноогоор үнэлсэн байна

95%


Эрүүл мэндийн байгууллагуудад ашиглагдаж байгаа цахим системүүд хоорондоо уялдаагүй, хөгжүүлэлт учир дутагдалтай байна

- ✓ Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс **health.gov.mn**
- ✓ Нэгдсэн эмнэлэг **e-health**,
- ✓ Сум өрхийн эрүүл мэндийн төвүүд **health.gov.mn**
- ✓ Эмийн сангууд **orion pharm, erp**

Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас холбогдох хууль тогтоомжийн талаар сургалт мэдээллийг хийж байгаа хэдий ч иргэдэд төдийлөн хүрэхгүй, тэдний мэдлэг, мэдээлэл дутмаг байна

Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй үнийн үйлчилгээний талаар иргэдээс авсан санал асуулгаар нийт иргэдийн 45 хувь нь хөнгөлөлттэй үнийн үйлчилгээг “мэдэхгүй” гэж хариулсан байна

- Мэднэ
- Мэдэхгүй



ЭМД-ын байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хэрхэн үнэлэх вэ? санал асуулгад оролцсон нийт иргэдийн 21.2 хувь нь хангалтгүй, 51.8 хувь нь “дунд” 27 хувь нь сайн гэж хариулсан байна





ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС

АУДИТЫН ДҮН



“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-нд хийсэн аудитаар нийт 22.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчил арилгуулах албан шаардлага 1, зөвлөмж 3, 22.1 сая төгрөгийн 8 төлбөрийн акт тогтоолоо.



АУДИТААС УЛАМЖЛАХ САНАЛ

Аудитын дүнд үндэслэн дараах саналыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэхээр ҮАГ-т уламжиллаа.

1

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтыг 3 жилд нэг удаа зохион байгуулж байгааг эргэн харах, нэмэлт шалгаруулалтад шаардлага хангасан ЭМБ бүр оролцох боломжийг бий болгох

2

Эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн байгууллагын ашиглаж байгаа цахим системийн хоорондын уялдаа холбоо, хөгжүүлэлтийг сайжруулан нэгдсэн нэг цахим системд шилжүүлэх

3

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг НДЕГ төвлөрүүлж, зарцуулалтыг ЭМДЕГ хариуцаж байгаа нь орлого, зарлагын нэгдсэн уялдаа холбоо хангагдахгүй байгаа тул тогтолцоог эргэн харах

Хаяг: Аймгийн ЗДТГ-ын А
корпус,
3-н давхар 312 тоот
Утас: 70333141
И-Мэйл: arkhangai@audit.gov.mn